



**ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН**

**Аудитын нэр: МАНДАЛ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

**Аудитад хамрагдсан жил: 2024**

**АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА: СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ДЭРГЭДЭХ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА**

**АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: “МАНДАЛ СУМЫН ТТЗ”**

**АУДИТ ХИЙГДСЭН ОБЪЕКТ: МАНДАЛ СУМ**

**АУДИТЫН ТӨРӨЛ: ДОТООД АУДИТ**

**АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА: 2024.12.12-2024.12.16**

**АУДИТАД ХАМРАГДСАН ХУГАЦАА: 2024 оны 4 дугаар улирал**

**Тайланг бэлтгэсэн:**  
**Дотоод аудитын нэгжийн удирдлагын дарга**  
Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга,  
СХШУАБ Т.Одсүрэн

**Аудитын багийн гишүүн:**  
Дотоод аудитор, СХШУБ  
Ц.Уртнасан

Огноо: 2024 оны 12 дүгээр сарын 16 өдөр

Сүхбаатар сумын 2 дугаар баг,  
Нутгийн удирдлагын II байр  
sankhuu\_audit\_se@yahoo.com

- 1. ТАНИЛЦУУЛГА
- 2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ,
  - 2.1. Аудитын зорилго
  - 2.2. Аудитын цар хүрээ
  - 2.3. Аудитын арга аргачлал, хязгаарлалт
- 3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА
  - 3.1. Засаглалын талаар
  - 3.2. Эрсдэлийн удирдлагын талаар
  - 3.3. Дотоод хяналтын талаар
- 4. АУДИТЫН ҮР ДҮН
  - 4.1. Илэрсэн асуудлууд
- 5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

## 1. ТАНИЛЦУУЛГА

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, "Дүрэм батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм", Дотоод аудитын хорооны 2024 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг аймгийн Засаг дарга бөгөөд Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 14 дүгээр удирдамжийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудитыг Засгийн газрын 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийг тус тус үндэслэн санхүүгийн хяналт шалгалт, эрх зүйн нийцлийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ба 2024 оны 3 дугаар улирлын үйл явцыг хамруулан, дахин тооцоолох, тулган шалгах хяналтын горимыг ашиглах, холбогдох ажилтнуудтай ярилцах, дотоод хяналтын орчныг судлах, үнэлэх, ажил гүйлгээг батлах, хянах, бүртгэх, тайлагнах процессын эрсдэлийг үнэлэх, мөрдвөл зохих хууль тогтоомжийн зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн байдлыг бодитоор илэрхийлж тогтоох, зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж байгаа байдлыг шалгуур үзүүлэлтээр тодорхойлж ажиллав.

## 2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

### 2.1 Аудитын зорилго:

Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

### 2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн удирдлага зохион байгуулалтын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг үнэлэх;

Аудитаар тус газрын 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг хамруулна. Үүнд:

- *Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлагын үйл явцыг үнэлэх;*
- *Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль, тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт.*
- *Төсвийн орлогын бүрдүүлэлт, санхүүжилт, хуваарилалт, үр дүн*
- *Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт үйл ажиллагааны үр дүн*
- *Хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр дүн*
- *Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ*

*худалдан авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилт*

- *Өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд тусгасан эсэх;*
- *Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналтын үр нөлөө*
- *Төрийн аудитын байгууллагаас 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил дутагдлын арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал*

#### **Аудитын хамрах хүрээний хязгаарлалт:**

Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны үйл ажиллагааны хамрах хүрээнд хязгаарлалт байхгүй болно.

#### **2.3 Аудитын арга, аргачлал**

Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон улсын стандарт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Монгол улсын сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэн албан тушаалтнаас асуулга тодруулга авах, нотлох зүйлсийг нягтлах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх горимуудыг ашиглав.

#### **2.4. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:**

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, журам, дүрэм, зааврыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Тратварын ерөнхий хууль
- Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам
- Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам
- УСНББОУС болон бусад стандартууд
- Төрийн сангийн төлбөр тооцооны журам
- Бусад хууль, эрх зүйн актууд

#### **2.5 Аудитын хугацаа, бүрэлдэхүүн**

Дотоод аудитыг 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс 2024 оны 12 дүгээр сарын 16-ны өдрийг хүртэлх хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дотоод аудитор, СХШУБ Ц.Уртнасан гүйцэтгэв.

### **3. Байгууллагын сайн туршлага**

Мандал сумын ЗДТГ, Хэрх, Түнхэл тосгоны захирагчийн алба нь Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын бодлого шийдвэр, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийн зорилтын хэрэгжилтийг зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавин, иргэдэд төрийн үйлчилгээг ил тод, түргэн шуурхай, нээлттэй, тэгш хүртээмжтэй хүргэн ажиллаж байна.

Мандал сумын хэмжээнд 2024 онд 09 сарын 30 байдлаар төрийн сангийн дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллахад анхан шатны баримтын бүрдэл дутуу, эдийн засгийн ангилал буруу шалтгаанаар буцаасан гүйлгээ нь 2023 оны өмнөх үетэй харьцуулахад 39 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ХХС-ийн чанаргүй зээлийн үлдэгдлийн хэмжээ өмнөх оноос 2023 онд 1.4 хувиар, 2024 оны 9 сарын байдлаар 6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Төсвийн байгууллагууд нь сар сардаа авлага, өглөгийг барагдуулж ажиллаж байгаа тул урсгал болон тогтмол зардлын төсвийн өр, авлага үүсгэхгүй ажилласан байна.

2020 он хүртэл аймгаас санхүүгийн дэмжлэг авч байсан бол 2020 оноос аймагт 1.9-2.2 тэрбум төгрөгийн орлогыг жилд төвлөрүүлсэн ба төсвийн татварын болон татварын бус орлого жилдээ 2022 онд 129.8 хувь, 2023 онд 112.5 хувь, 2024 оны 09 сарын байдлаар 129.5 хувь буюу тогтмол давуулан биелүүлсэн байна.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 2021, 2022, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт авсан байна.

Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн нэгдсэн дүнгээр Мандал сум нь 2021 онд “Шилдэг сум” гутгаар байр, 2023 онд “Шилдэг сум” тэргүүн байранд орж шагнагдсан байна.

#### **3.1 Засаглалын талаар**

Сэлэнгэ аймгийн Мандал сумын удирдлагын баг нь орон нутгийн 9 дэх удаагийн сонгуулийн үр дүнгээр зохин байгуулсан ИТХ-ын анхдугаар хуралдаанаар Н.Батбаяр ИТХ-ын даргаар томилж, Д.Хадбаатар Засаг даргаар томилогдсон байна. Бидний хяналт шалгалтад хамрагдах хугацаа нь өмнөх удирдлагын үеийн шийдвэр гаргалттай холбоотойг онцлон дурдах нь зүйтэй юм.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын удирдлагын багийн удирдлагад сумын ИТХ-ын даргаар Н.Эрдэнэцэцэг 2022 оны 01 сарын 18 өдрөөс 2024 оны 10 сарын 28 өдөр хүртэл, Н.Батбаяр нь 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс хойш, сумын Засаг

даргаар А.Дашзэвэг нь 2022 оны 12 сарын 12 өдрөөс 2024 оны 11 сарын 27 өдөр хүртэл, Д.Хадбаатар нь 2024 оны 11 сарын 27 өдрөөс томилогдон, Засаг даргын орлогч Н.Батбаяр нь 2023 оны 09 сарын 11 өдрөөс 2024 оны 10 сарын 28 өдөр хүртэл, Э.Баярхүү 2024 оны 12 сарын 04 өдөр томилогдсон. Хэрх 4 багийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгчээр Э.Өлзийсайхан 2023 оны 08 сарын 21 өдрөөс өнөөдрийг хүртэл, Түнхэл 5 багийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгчээр Х.Хүрэл-Эрдэнэ 2021 оны 01 сарын 07 өдрөөс өнөөдрийг хүртэл, 1 багийн Засаг даргаар Б.Сүхболд 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрөөс өнөөдрийг хүртэл, 2 дугаар багийн Засаг даргыг түр орлон гүйцэтгэгчээр Г.Дашдаваа 2023 оны 02 дугаар сарын 01-ны өдрөөс өнөөдрийг хүртэл, 3 багийн Засаг даргаар Б.Бат-Эрдэнэ 2022 оны 05 сарын 19 өдрөөс өнөөдрийг хүртэл, 6 багийн Засаг дарга Д.Гэрэлцэцэг 2023 оны 07 сарын 26 өдрөөс өнөөдрийг хүртэл, 7 багийн Засаг дарга Б.Отгонбаяр 2022 оны 05 сарын 19 өдрөөс өнөөдрийг хүртэл, 8 багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ганзориг 2023 оны 09 сарын 18 өдрөөс өнөөдрийг хүртэл, 9 багийн Засаг дарга Б.Оюунцэцэг 2022 оны 05 сарын 19 өдрөөс өнөөдрийг хүртэл, сумын төсвийн ерөнхий нягтлан бодогч Б.Энхтуяа 2016 оны 01 сарын 01 өдрөөс өнөөдрийг хүртэл тус тус ажиллаж байна.

Сумын Засаг дарга Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын бодлого шийдвэр, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийн зорилтын хэрэгжилтийг зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавин, иргэдэд төрийн үйлчилгээг ил тод, түргэн шуурхай, нээлттэй, тэгш хүртээмжтэй хүргэхэд гол ажлуудыг шийдвэрлэсэн байна.

Аймгийн Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсээс Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын хэрэгжилтийг ханган хагас бүтэн жилээр бүх шатны захиргааны байгууллага нь өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.

Мандал сумын ЗДТГ-ын даргын 2023 оны 12 сарын 26 өдрийн А/31 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хороо байгуулсан. Үүний дагуу Мандал сумын төр, төсөв, ОНӨААТҮГ-ын 40 байгууллагын ёс зүйн дэд хороог байгуулж, 84 албан хаагчийг хамруулсан хэлэлцүүлэг хийж Ёс зүйн дэд хорооны жилийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж ажилласан байна.

### **3.2 Эрсдэлийн удирдлагын талаар**

Тус сум нь эрсдэлийн удирдлагын бодлого, журам боловсруулаагүй, тусдаа хариуцсан ажилтан нэгж байгуулаагүй, одоогоор эрсдэлийн бүртгэл байхгүй. Сумын Засаг даргаар 2024 оны 01 сарын 10 өдөр 2024 онд хийж гүйцэтгэх дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг санхүү, бүртгэлийн чиглэлээр батлуулж хэрэгжилтийг дүгнэж ажилласан байна. 2024 оны 09 сарын байдлаар хэрэгжилт гүйцэтгэл 98.2 хувьтай байна.

Мандал сумын Санхүүгийн албанаас тус сумын төсвийн байгууллагуудын 2023 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад 96.6 хувьтай дүгнэсэн ба Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2023 оны мэдээ байршуулсан тайлангаар тус сумын гүйцэтгэлийг 72.4 хувьтай дүгнэгдсэн байна. 2024 оны 12 сарын 06 өдрийн байдлаар Мандал сумын Санхүүгийн албанаас тус сумын төсвийн байгууллагуудын 2024 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад 89.9 хувийн гүйцэтгэлтэйгээр дүгнэж алдаа зөрчлийн арилгах, давтан гаргахгүй ажиллахад анхаарч ажилласан байна.

Байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвшлийг тодорхойлоход эрсдэлийн соёл, эрсдэлийн засаглал, эрсдэлийн үйл явц эхлэлийн буюу 2-р түвшинд байна.

### 3.3 Дотоод хяналтын системийн талаар

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг Зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.5. Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө. 3.1. Энэхүү журмын 1.3-т заасан "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-д өөрөөр заагаагүй бол дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүргийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны асуудал хариуцсан нэгж, ажилтан (цаашид "дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан" гэх) гүйцэтгэнэ. гэж заасан байдаг боловч төсвийн төвлөрүүлэн захирагчид шууд харьяалагдах дотоод хяналт хариуцсан ажилтны орон тоо байхгүйгээс одоог хүртэл батлуулаагүй байна.

Дотоод хяналтыг удирдамж, төлөвлөгөөг зөвхөн харьяа нэгжүүд өөрсдийн чиг үүргийн дагуу хийж байгаа нь нэгдсэн удирдлагын тогтолцоо бүрдээгүйг илэрхийлж байна.

## 4. АУДИТЫН ҮР ДҮН

<b><u>Илэрсэн асуудал 1</u></b>	Эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй Аюул эрсдэлийг тодорхой хэмжээнд ярилцдаг боловч баримтжуулаагүй.
<b><u>Асуудлын ангилал</u></b>	Нөлөө их
<b>Бодит байдал:</b> Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөхдөө учирч болох эрсдэлүүдийг авч бүртгэж түүнийг бууруулах талаар ярилцдаг боловч баримтжуулаагүй, үнэлгээ хийгдээгүй байна.	
<b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b> Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт-2120	
<b>Асуудлын үндсэн шалтгаан:</b> Эрсдэлийн үнэлгээний ерөнхий ойлголт, ач холбогдол, үнэлгээ хийх арга аргачлалын талаар холбогдох албан тушаалтанд сургалт зохион байгуулдаггүй Эрсдэлийг зөвхөн шаардлагатай үед тодорхойлдог боловч бүрэн үнэлдэггүй.	

**Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:**

- Эрсдэлээ тодорхойлоогүй нөхцөлд байгууллага зорилгодоо хүрэхэд саад бэрхшээл тулгарах

- Байгууллагын үнэ цэн буурна, төсөв санхүүгийн хүндрэл учирч хэвийн үйл ажиллагаа алдагдана

**Шийдвэр:**

Байгууллагын албан хаагчдад эрсдэлийн талаар ойлголт өгч, дотоод хяналтын нэгж хариуцсан ажиллагсдыг сургалтад үе шаттай хамруулж, чадавхжуулах

-Гүйцэтгэх удирдлага нь байгууллагын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэхдээ эрсдэлийн чиглэлээр ур чадвар бүхий ажилтан сонгон шалгаруулж авах

-Байгууллагын эрсдэлийн түвшинг нэг шатлал ахиулан давтамжтай түвшинд шилжих зөвлөмж хүргүүлэх

**Илэрсэн асуудал 2**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээнд хэрэгжүүлэх дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулаагүй байна.

**Асуудлын ангилал**

Нөлөө их

**Бодит байдал:**

Төсвийн төвлөрүүлэн захирагчид шууд харьяалагдах дотоод хяналт хариуцсан ажилтны орон тоо байхгүйгээс одоог хүртэл батлуулаагүй. Сумын хэмжээнд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмыг боловсруулж батлуулаагүй байна.

**Байх ёстой шаардлага /шалгуур/:**

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.4. дэх "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана."

**Асуудлын үндсэн шалтгаан:**

Дотоод хяналт хэрэгжүүлэг төлөвлөгөө боловсруулаагүй, дотоод хяналтын чиглэлээр ажил зохион байгуулаагүй үндсэн үйл ажиллагаанд болон гүйцэтгэх удирдлагад тавих хяналтын тогтолцоог журамлаагүй, хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулах хяналтуудыг орхигдуулсан.

**Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:**

Удирдлагын хяналт, гүйцэтгэх удирдлагын уялдаа холбоо хангагдаагүй хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхой бусад нэгжийн дотоод хяналын үр нөлөө сул үнэлгээ дүгнэлт хангалтгүй байна.

**Шийдвэр:**

Өөрийн эрхлэх хүрээний асуудал хариуцсан байгууллагууд болон гүйцэтгэх удирдлага, болон үндсэн үйл ажиллагаанд хийх дотоод хяналт шалгалтын журмыг нэн яаралтай боловсруулах, дотоод хяналт хариуцсан ажилтантай болгож албан тушаалын тодорхойлолтод холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын заалтаар тусгаж өгөх. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл

үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.4. дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлэх

<b><u>Илэрсэн асуудал 3</u></b>	Сумын ИТХ-аар 2024 оны төсөв батлагдсаны дараа ОНХС-аар хийгдэх нийт 1,160,797.4 мянган төгрөгийн ажлын зураг төсвийг баталсан байна.
<b><u>Асуудлын ангилал</u></b>	Нөлөө их
<b>Бодит байдал:</b> Сумын ИТХ-ын 2023 оны 12 сарын 18 өдрийн 115 дугаар "Мандал сумын 2024 оны төсөв батлах тухай" тогтоол батлагдсаны дараа ОНХС-аар хийгдэх Хаягжуулалт 153,811.6 мянган төгрөгийн, Камержуулалт 1,006,985.8 мянган төгрөгийн ажлын зураг төсвийг баталсан ба тендер шалгаруулсан байна.	
<b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b> Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана."	
<b>Асуудлын үндсэн шалтгаан:</b> Хаягжуулалтын ажил төсөв батлуулаагүй, камержуулалтын ажил иргэдээс эрэмбэлэгдсэн саналд орсон боловч сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн аюулгүй байдлын үүднээс сумын ИТХ-аас санал оруулж батлуулснаас шалтгаалж зураг, төсвийг төсөв батлагдсаны дараа батлуулсан байна.	
<b>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</b> ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хуулийн дагуу хэрэгжүүлээгүй, хууль тогтоомж мөрдөж ажиллахгүй байх.	
<b>Шийдвэр:</b> ОНХС-аар хийгдэх төсөл, арга хэмжээний төсвийг батлахдаа хөрөнгө оруулалтын төсөв, техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгаж, хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх	

<b><u>Илэрсэн асуудал 4</u></b>	ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн нийт 1,304,134.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээний гүйцэтгэл дутуу, гэрээний хугацаандаа бүрэн хэрэгжиж дуусаагүй байгаа нь төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн, үр ашигт тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.
<b><u>Асуудлын ангилал</u></b>	Нөлөө их
<b>Бодит байдал:</b> ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх нийт 1,304,134.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээ гэрээний хугацаанд бүрэн хэрэгжиж дуусаагүй, гүйцэтгэл дутуу байна. Үүнд: - 1,1 км бетонон хучилттай авто зам /3, 7-р баг/ 692,954.9 мянган төгрөгийн, - Тултын тохойн гүүр засварлах 50,000.0 мянган төгрөгийн, - Тоглоомын талбай байгуулах /9-р баг/ 281,179.1 мянган төгрөгийн, - Гудамжны шороон зам засварлах 280,000.0 мянган төгрөгийн ажлууд байна.	
<b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b>	

Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.7.хууль тогтоомж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энэ хуулийн 22.1-д заасан асуудлаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах; Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.8 дахь “хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах”, захиалагч тал болох сумын ЗДТГ, гүйцэтгэгч компанитай байгуулсан гэрээний 4.12 дахь “Гүйцэтгэгч гэрээний хугацааг хэтрүүлсэн тохиолдолд алданги ногдуулах хэмжээний хоногт гэрээний үнийн 0.05 хувь байна”, 4.13 дахь “Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 10 хувь байна. Алдангийг ажил гүйцэтгэх үе шатны графикаар тооцох бөгөөд нийт алдангийн хэмжээ гэрээний үнийн дүнгийн 10 хувьд хүрсэн тохиолдолд гэрээ цуцлагдах үндэслэл болно”

**Асуудлын үндсэн шалтгаан:**  
Гүйцэтгэгч компаниуд ажлаа гүйцэт хийгээгүйгээс шалтгаалан хугацаандаа хийж дуусгаагүй байна.

**Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:**  
ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн, үр ашигт тавих хяналт хангалтгүй байх.

**Шийдвэр:**  
Төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн, үр ашигт тавих хяналтыг сайжруулах, ОНХС -аар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр арга хэмжээний гүйцэтгэгчээр шалгарсан боловч гэрээний дагуу хугацаандаа гүйцэтгээгүй компаниудыг шүүхэд шилжүүлэх албан шаардлага хүргүүлэх

<b><u>Илэрсэн асуудал 5</u></b>	Сумын ИТХ-ийн тогтоолоор ОНХС-ийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээн 3 жил дараалан нийт <b>72,118.4</b> мянган төгрөгийн төсөвт өртөгтэй зураг төсвийн ажлыг батлан оруулсан байна.
<b><u>Асуудлын ангилал</u></b>	Нөлөө дунд
<b>Бодит байдал:</b> Сумын ИТХ-ын 2023 оны 115 дугаар “Мандал сумын 2024 оны төсөв батлах” тухай тогтоолд “Орон нутаг судлах музейн барилгын зураг төсөв боловсруулах” 32118.4 мянган төгрөгийн, “Хэрх тосгоны спорт заалны барилгын зураг төсөв боловсруулах” 20,000.0 мянган төгрөгийн, “Зүүнхараа политехник коллежийн спорт заалны барилгын зураг төсөв боловсруулах” 20,000.0 мянган төгрөгийн зураг төсвийн ажлыг 3 жил дараалан сумын ИТХ-ийн тогтоолоор ОНХС-ийн хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт баталж оруулсан байна.	
<b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b> Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5 дахь “Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй.”	
<b>Асуудлын үндсэн шалтгаан:</b> Сумын ИТХ-ын төлөөлөгчдийн саналаар төсөвт тусгагдсан.	
<b>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</b> Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй байх, төсөл арга хэмжээний үр нөлөө буурах, чанаргүй хийгдэх.	
<b>Шийдвэр:</b> Төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн, үр ашигт тавих хяналтыг сайжруулах, Төсвийн тухай хуулийн 43.5 дахь заалтыг мөрдөж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх	

## 5.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу дотоод аудитыг хийж гүйцэтгэхэд илэрсэн алдаа зөрчлийг үндэслэн “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг өгч байна.

Байгууллага өөрийн зорилгодоо хүрэхийн тулд эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэн, дотоод хяналтыг үр нөлөөг сайжруулах тогтолцоог бий болгож шийдвэр гаргалтад түүнийг үр дүнтэй ашиглаж хэвших шаардлагатай байна..

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Сайжруулах шаардлагатай	Засаглал эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “эхлэлийн буюу 2-р түвшин”-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 50 хувь нь “нөлөө ихтэй” гэж үзсэн.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ДОТООД АУДИТОР, СХИҮБЭГЧИЙН Д.УРТНАСАН


ТАЙЛАН ХЯНАСАН:

АЛБАНЫ ДАРГА Т.ОДСҮРЭН

ТАНИЛЦСАН:

МАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА Д.ХАДБААТАР

ТӨСВИЙН ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧ Б.ЭНХТУЯА





СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН АЛБА  
УЛСЫН БАЙЦААГЧИЙН  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 130/3д-03

Сүхбаатар сум

**Зөрчил арилгуулах тухай**

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 09 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт заасан хяналт шалгалтын байгууллага (Улсын байцаагч)-ын бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 14 дугаартай удирдамжийн дагуу Мандал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 3 дугаар улирлын үйл ажиллагааны үр дүнд хийсэн дотоод аудитаар сумын Игэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд 5 жил дараалан нийт 72,118.400 төгрөгийн төсөвт өртөгтэй зураг төсвийн ажлыг батлан оруулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5 дахь "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбоогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д "Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ." гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн, үр ашигт тавих хяналтыг сайжруулах, Төсвийн тухай хуулийн 43.5 дахь заалтыг мөрдөж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.
2. Цаашид дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 01 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд ирүүлэхийг Мандал сумын Засаг дарга Д.Хадбаатар, Ерөнхий нягтлан бодогч Б.Энхтуяа нарт даалгав.


3. Улсын байцаагчийн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16.2, Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1.3-д зааснаар хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Энэхүү албан шаардлагыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД  
 АУДИТЫН АЛБАНЫ ДОТООД  
 АУДИТОР ОМОНГОЛ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ  
 ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ  
 Ц.УРТНАСАН



**ЗӨВШӨӨРСӨН:**





СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН АЛБА  
УЛСЫН БАЙЦААГЧИЙН  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 131/32-02

Сүхбаатар сум

Зөрчил арилгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 09 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт заасан хяналт шалгалтын байгууллага (Улсын байцаагч)-ын бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 14 дугаартай удирдамжийн дагуу Мандал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 3 дугаар улирлын үйл ажиллагааны үр дүнд хийсэн дотоод аудитаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлсэн нийт 1,304,134.000 төгрөгийн ажил гэрээний хугацаандаа бүрэн хэрэгжиж дуусаагүй зөрчил илэрлээ.


Энэ нь Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.7.хууль тогтоомж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энэ хуулийн 22.1-д заасан асуудлаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах; Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.8 дахь "хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнаж", захиалагч тал болох сумын ЗДТГ, гүйцэтгэгч компанитай байгуулсан гэрээний 4.12 дахь "Гүйцэтгэгч гэрээний хугацааг хэтрүүлсэн тохиолдолд алданги ногдуулах хэмжээний хоногт гэрээний үнийн 0.05 хувь байна", 4.13 дахь "Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 10 хувь байна. Алдангийг ажил гүйцэтгэх үе шатны графикаар тооцох бөгөөд нийт алдангийн хэмжээ гэрээний үнийн дүнгийн 10 хувьд хүрсэн тохиолдолд гэрээ цуцлагдах үндэслэл болно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д "Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ." гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн, үр ашигт тавих хяналтыг сайжруулах, Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр арга хэмжээний гүйцэтгэгчээр шалгарсан боловч гэрээний дагуу хугацаандаа гүйцэтгээгүй компаниудыг шүүхэд шилжүүлэх.
2. Цаашид дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 01 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд ирүүлэхийг Мандал сумын Засаг дарга Д.Хадбаатар, Ерөнхий нягтлан бодогч Б.Энхтуяа нарт даалгав.
3. Улсын байцаагчийн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16.2, Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1.3-д зааснаар хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Энэхүү албан шаардлагыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.


**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД  
 АУДИТЫН АЛБАНЫ ДОТООД  
 АУДИТОР ШАЛГАЛТЫН  
 УЛСЫН БАЙЦААГЧ  
 Ц.УРТНАСАН



**ЗӨВШӨӨРСӨН:**

СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ  
 СУМЫН ЗАСАГ ДАРГА  
 Д.ХАДБААТАР  
 ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ  
 Б.ЭНХТУЯА





СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН АЛБА  
УЛСЫН БАЙЦААГЧИЙН  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 10 сарын 17 өдөр

Дугаар 132/22-05

Сүхбаатар сум

Зөрчил арилгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 09 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт заасан хяналт шалгалтын байгууллага (Улсын байцаагч)-ын бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 14 дугаартай удирдамжийн дагуу Мандал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 3 дугаар улирлын үйл ажиллагааны үр дүнд хийсэн дотоод аудитаар сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор 2024 оны төсөв батлагдсаны дараа Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх нийт 1,160,797.400 төгрөгийн ажлын зураг төсвийг баталж, хэрэгжүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д "Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ." гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. ОНХС-аар хийгдэх төсөл, арга хэмжээний төсвийг батлахдаа хөрөнгө оруулалтын төсөв, техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгаж, хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.
2. Цаашид дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 01 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд ирүүлэхийг Мандал сумын Засаг дарга Д.Хадбаатар, Ерөнхий нягтлан бодогч Б.Энхтуяа нарт даалгав.

3. Улсын байцаагчийн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16.2, Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1.3-д зааснаар хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Энэхүү албан шаардлагыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД  
АУДИТЫН АЛБАНЫ ДОТООД  
АУДИТОР САНХҮҮГИЙН ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫН ДУУСЫН БАЙЦААГЧ  
Ц.УРТНАСАН



ЗӨВШӨӨРСӨН:

